



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 1/93

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн “а”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Булган сумын Бүрэнхайрхан багийн нутаг дэвсгэрт “Ховдын өргөө” ХХК-ний барьсан 50 ортой нэгдсэн эмнэлгийн барилгын барилга угсралтын ажилд нэмэлт гэрээ байгуулах боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Т.Жаргалсайхан	-Аймгийн Засаг даргын орлогч
Гишүүд: Н.Ганзориг	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрхзүйн хэлтсийн дарга
Ш.Нохойжав	-Орон нутгийн өмчийн газрын дарга
Б.Батмөнх	-“Ховдын өргөө” ХХК-ний хуулийн зөвлөх
Т.Энхзаяа	-“Ховдын өргөө” ХХК-ний барилгын инженер
Нарийн бичгийн дарга: Б.Түмэндэмбэрэл	-Аймгийн ерөнхий архитектор бөгөөд Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Барилга хот байгуулалт, газрын харилцааны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

2. Ховд аймгийн Булган сумын Бүрэнхайрхан багийн нутаг дэвсгэрт “Ховдын өргөө” ХХК-ний барьсан 50 ортой нэгдсэн эмнэлгийн барилгын барилга угсралтын

Зах А/93 Г/у  
02 00424

ажилд нэмэлт гэрээ байгуулах боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор багтаан гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ